



2018 оны 06 дугаар сарын 05  
№21/1026/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын  
хууль**

**Гаалийн албан татвараас  
чөлөөлөх тухай**

**Монгол Улсын  
Их Хурлын  
тогтоол**

**Үндсэн хуулийн цэцийн  
гишүүнээр томилох тухай**

**Монгол Улсын  
Үндсэн хуулийн  
цэцийн дүгнэлт**

**“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх  
тухай хуулийн зарим заалт  
Үндсэн хуулийн холбогдох  
заалтыг зөрчсөн эсэх маргааныг  
хянан шийдвэрлэсэн тухай**

**ГАРЧИГ**  
**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

187.	Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай		638
188.	Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай		638
189.	Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай		639
190.	Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай		639

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

191.	Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс чөлөөлөх тухай	Дугаар 32	640
192.	Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох тухай	Дугаар 33	640
193.	Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай	Дугаар 34	641
194.	Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох тухай	Дугаар 35	641
195.	Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай	Дугаар 36	642

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

196.	Улсын дээд шүүхийн танхимын тэргүүнийг томилох тухай	Дугаар 50	642
------	--	-----------	-----

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

197.	Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 43	643
------	--	-----------	-----

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

198.	“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай	Дугаар 06	647
------	---	-----------	-----



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 05 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Импортоор оруулж байгаа гуалингаас бусад бүх төрлийн түлшний зориулалтын мод, тууш чиглэлийн нимгэн давхаргатай хавтан /OSB/, стандартын дагуу хийгдсэн, угсрахад бэлэн модон барилгын угсармал хийцийг гаалийн албан татвараас 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд тус тус чөлөөлсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан барааны жагсаалтыг “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/”-ийн ангиллын дагуу Засгийн газар батална.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 05 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг 2018 оны 05 дугаар сарын 10-ны өдөр баталсантай холбогдуулан 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд импортоор оруулсан тууш чиглэлийн нимгэн давхаргатай хавтан /OSB/, стандартын дагуу хийгдсэн, угсрахад бэлэн модон барилгын угсармал хийцэд ногдуулсан гаалийн албан татварыг татвар төлөгчид буцаан олгоно.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2018 оны 05 дугаар сарын 10-ны өдөр баталсан Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 05 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Ойжуулалт, цэцэрлэгжүүлэлт, ойн аж ахуйн арга хэмжээний ажил болон импортоор оруулж байгаа гуалингаас бусад бүх төрлийн түлшний зориулалтын мод, тууш чиглэлийн нимгэн давхаргатай хавтан /OSB/, стандартын дагуу хийгдсэн, угсрахад бэлэн модон барилгын угсармал хийцийг нэмэгдсэн өртгийн албан татвараас 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд тус тус чөлөөлсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан ойжуулалт, цэцэрлэгжүүлэлт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлын жагсаалт болон импортоор оруулж байгаа барааны жагсаалтыг “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/”-ийн ангиллын дагуу Засгийн газар батална.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 05 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг 2018 оны 05 дугаар сарын 10-ны өдөр баталсантай холбогдуулан 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ойжуулалт, цэцэрлэгжүүлэлт, ойн аж ахуйн арга хэмжээний ажил болон импортоор оруулсан тууш чиглэлийн нимгэн давхаргатай хавтан /OSB/, стандартын дагуу хийгдсэн, угсрахад бэлэн модон барилгын угсармал хийцэд ногдуулсан нэмэгдсэн өртгийн албан татварыг татвар төлөгчид буцаан олгоно.



**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2018 оны 05 дугаар сарын 10-ны өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 05 дугаар  
сарын 25-ны өдөр

Дугаар 32

Улаанбаатар  
хот

**Сонгуулийн ерөнхий хорооны  
гишүүнээс чөлөөлөх тухай**

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс Шилагарьдын Солонгыг чөлөөлсүгэй.

2. Энэ тогтоолыг 2018 оны 05 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 05 дугаар  
сарын 24-ний өдөр

Дугаар 33

Улаанбаатар  
хот

**Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр  
томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын санал болгосноор Шилагарьдын Солонгыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилсугай.

2.Энэ тогтоолыг 2018 оны 05 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 05 дугаар  
сарын 24-ний өдөр

Дугаар 34

Улаанбаатар  
хот

**Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс  
чөлөөлөх тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон тул Дуламын Сугарыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2018 оны 05 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 05 дугаар  
сарын 24-ний өдөр

Дугаар 35

Улаанбаатар  
хот

**Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр  
томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болгосноор Батсүхийн Буяндэлгэр, Цагааны Нанзаддорж, Гомбожавын Туулхүү нарыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилсугай.



2.Энэ тогтоолыг 2018 оны 05 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

### **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 05 дугаар  
сарын 24-ний өдөр

Дугаар 36

Улаанбаатар  
хот

#### **Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон тул Наваанпэрэнлэйн Жанцан, Тогоочийн Лхагваа, Даваасүрэнгийн Наранчимэг нарыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2018 оны 05 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

### **МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2018 оны 05 дугаар  
сарын 22-ны өдөр

Дугаар 50

Улаанбаатар  
хот

#### **Улсын дээд шүүхийн танхимын тэргүүнийг томилох тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Хээмчигийн Сонинбаярыг Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүнээр томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН  
БАТТУЛГА**



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 2 дугаар  
сарын 6-ны өдөр

Дугаар 43

Улаанбаатар  
хот

### **Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай**

Агаарын тухай хуулийн 6.1.5, 6.1.7, 6.1.9-6.1.11 дэх заалтыг тус тус үндэслэн Улсын Их Хурлын 2018 оны 2 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Агаарын бохирдлыг бууруулах зорилтын хүрээнд дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дараах байгууллага, албан тушаалтанд даалгасугай:

1.1. нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд түүхий нүүрсний хэрэглээг үе шаттайгаар бүсчлэн хориглох арга хэмжээ авч, сайжруулсан түлшний хэрэглээг дэмжих, халаалтын бага, дунд, том оврын зуухнуудад эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй технологийн шинэчлэлт хийх, халаалтын зуухнуудыг үе шаттайгаар төвлөрсөн дулааны шугам сүлжээнд холбох ажлыг 2018 онд багтаан зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Нийслэлийн Засаг дарга С.Батболд нарт;

1.2. гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулахад шаардлагатай нийгмийн болон инженерийн дэд бүтэц, шугам сүлжээг бий болгож, барилга угсралтын ажлыг эрчимжүүлэх, инженерийн хангамжийн “Дэд бүтцийн төв” төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтыг улс, нийслэлийн төсөв, гадаадын зээл, тусламж болон гадаад, дотоодын хөрөнгө оруулагч нарыг татан оролцуулах замаар нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Нийслэлийн Засаг дарга С.Батболд нарт;

1.3. зах зээл дээр борлогдоогүй байгаа орон сууцны талаарх судалгааг нарийвчлан гаргаж, тэдгээрийг эргэлтэд оруулах арга хэмжээг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан залуу гэр бүл, 18 хүртэлх насны 4 болон түүнээс дээш хүүхэдтэй гэр бүл, малчид, төрийн албан хаагчдыг орон сууцжуулах зорилттой уялдуулан хэрэгжүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Нийслэлийн Засаг дарга С.Батболд нарт;





1.4. улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр баригдсан бөгөөд бүрэн ашиглалтад оруулж чадаагүй “ДЦС-2” ТӨХК-ийн дэргэдэх сайжруулсан түлшний үйлдвэрийг түшиглэн нийслэлийн гэр хорооллын айл өрхийг сайжруулсан түлшээр хангах бие даасан аж ахуйн тооцоотой улсын үйлдвэрийн газрыг байгуулах асуудлыг судалж, саналаа 2018 оны 2 дугаар сард багтаан Засгийн газарт танилцуулахыг Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-г;

1.5. эрчим хүчний хэмнэлттэй ахуйн цахилгаан халаагуур, сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж худалдан авах иргэдэд зориулсан бага хүүтэй, урт хугацаатай зээлийн бүтээгдэхүүн нэвтрүүлэх асуудлыг судалж, саналаа 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт, амины орон сууцны байшин, гэрийн дулааны алдагдлыг бууруулах дэвшилтэт технологи нэвтрүүлэх санал, санаачилгыг дэмжиж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад холбогдох хууль тогтоомжийн дагуу дэмжлэг үзүүлж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Нийслэлийн Засаг дарга С.Батболд нарт;

1.6. эрчим хүчний хэмнэлт, дулааны алдагдалгүй хэрэглээ, ногоон худалдан авалтыг дэмжин иргэд, байгууллагын хандлагыг өөрчлөх замаар агаар, орчны бохирдлыг бууруулах, олон нийтийн оролцоог хангасан “Бид нэг агаартай” аяныг тогтмол зохион байгуулж байхыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Нийслэлийн Засаг дарга С.Батболд нарт;

1.7. нийтийн тээврийн хэрэгслийг цахилгаан болон хийн түлшний хэрэглээнд үе шаттайгаар шилжүүлэх, Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээнд Тусгай замын автобус (BRT) системийг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Нийслэлийн Засаг дарга С.Батболд, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт;

1.8. нийтийн тээврийн үйлчилгээний стандартын шаардлага хангасан 24 болон түүнээс дээш суудалтай, 48 болон түүнээс дээш зорчигчийн багтаамжтай, үйлдвэрлэгдсэн оноос хойш нэг хүртэл жилийн дотор импортоор оруулж ирэх цахилгаан тэжээлт болон шингэрүүлсэн хийгээр ажилладаг автобус, троллейбус, такси үйлчилгээнд зориулан тусгайлан үйлдвэрлэсэн автомашиныг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх асуудлыг судалж, 2018 оны 3 дугаар

сарын 15-ны өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Зам, тээвэр хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат нарт;

1.9. үндэсний үйлдвэрлэлийг дэмжих талаар төрөөс баримталж байгаа бодлогын хүрээнд дотооддоо автобус, троллейбус үйлдвэрлэж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт;

1.10. Улаанбаатар хотын дагуул хот, үйлдвэрлэл, технологийн паркийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр болон жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах, гадаадын зээл, тусламжид хамруулах талаар дэмжлэг үзүүлж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан нарт, дагуул хот, дэд төв, үйлдвэрлэл, технологийн паркийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг, Нийслэлийн Засаг дарга С.Батболд нарт;

1.11. гэр хорооллын суурьшлын бүсэд хэсэгчилсэн инженерийн хангамжийн дэд төвүүд барьж байгуулахтай холбогдуулан стандарт боловсруулж батлуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Нийслэлийн Засаг дарга С.Батболд нарт;

1.12. хот, суурин газрын агаарын бохирдлыг бууруулах, агаарын чанарыг сайжруулах үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын тохируулагч агентлаг байгуулах асуудлыг судалж, холбогдох шийдвэрийн төслийг боловсруулан 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат нарт;

1.13. 2018 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн дотор нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын бүтцэд агаарын чанарт хяналт тавих үүрэг бүхий нэгжийг шинээр байгуулж, шаардагдах зардлыг батлагдсан төсвийн багцдаа зохицуулалт хийх замаар шийдвэрлэхийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүүд;

1.14. нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх хууль тогтоомж, журмын хэрэгжилтэд тавих хяналт шалгалтын



ажлыг эрчимжүүлж, явц, дүнг улирал тутам Засгийн газарт танилцуулж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүү, Нийслэлийн Засаг дарга С.Батболд нарт;

1.15. аймаг, нийслэл, сум, дүүрэгт харьяа нэгжтэй Засгийн газрын зарим агентлаг болон төрийн байгууллага, төрийн өмчит их, дээд сургуулиудыг хотын төвөөс нүүлгэн шилжүүлэх асуудлыг судалж, саналаа холбогдох тооцоо, судалгааны хамт 2018 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаа, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Нийслэлийн Засаг дарга С.Батболд нарт;

1.16. Улаанбаатар хотын дагуул хот, тосгон болон нүүлгэн шилжүүлэх их, дээд сургуулиудын хотхоныг холбох хурдны зам, дэд бүтэц байгуулах асуудлыг судалж, холбогдох тооцоо, судалгаа бүхий саналыг 2018 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Нийслэлийн Засаг дарга С.Батболд нарт;

1.17. иргэдийн орлогод нийцсэн хямд өртөгтэй орон сууц болон түрээсийн орон сууц барихад шаардагдах хөрөнгийг зориулалтын сан, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Нийслэлийн Засаг дарга С.Батболд нарт;

1.18. нийслэлээс орон нутагт шилжин суурьшиж мал аж ахуй, газар тариалан эрхлэх сонирхолтой иргэдийг дэмжин ажлын байраар хангах, урамшуулах асуудлыг судлан, тодорхой санал боловсруулж 2018 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;

1.19. иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг зөрчин агаар, орчныг бохирдуулж байгаа үйлдэлд хариуцлага тооцох эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр холбогдох хуулийн төслийг боловсруулж, 2018 оны 4 дүгээр сарын 1-ний дотор Засгийн газарт оруулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл нарт.



2. Хот, суурин газрын агаарын бохирдлыг бууруулах зорилтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн тооцоог хийж 2018 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг улирал тутам танилцуулж байхыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбатад тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**У.ХҮРЭЛСҮХ**

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

**Н.ЦЭРЭНБАТ**

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

2018 оны 5 дугаар  
сарын 23-ны өдөр

Дугаар 06

Улаанбаатар  
хот

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зарим  
заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн  
эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн  
хуралдааны танхим 12.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Н.Жанцан даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Ш.Цогтоо, Н.Чинбат /илтгэгч/, Д.Солонго, Д.Ганзориг нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл, гомдол гаргагч, иргэн Т.Мөнх-Эрдэнэ болон Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 6 дугаар сарын 9-ний өдөр баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2.13 дахь заалт Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн "... өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.", Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтын "хөдлөх ... хөрөнгө эзэмших, өмчлөх ... эрхтэй." гэсэн хэсгийг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.



***Нэг. Нийслэлийн Баянгол дүүргийн 17 дугаар хорооны оршин суугч, иргэн Т.Мөнх-Эрдэнэ, Хан-Уул дүүргийн 11 дүгээр хорооны оршин суугч, иргэн Г.Орхон нар Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан мэдээлэл, гомдолдоо:***

1. “Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад иргэн нь “хөдлөх ... хөрөнгө эзэмших, өмчлөх ... эрхтэй. ...” гэж үндсэн эрхийг баталгаажуулсан байна. Хөдлөх хөрөнгө гэдэг нь үл хөдлөх эд хөрөнгөөс бусад хөрөнгө мөн. Харин өмчлөх эрх гэж өмчлөгч өөрийн хөрөнгөө хуулийн хүрээнд бүрэн мэдэж эзэмших, ашиглах, захиран зарцуулахыг ойлгоно. Өөрөөр хэлбэл, тодорхой этгээд өөрт байгаа эд хөрөнгийг хуулийн хэмжээ хязгаарын хүрээнд өөрийн үзэмж, ашиг сонирхлоор буюу бусад этгээдийн нөлөөллөөс үл шалтгаалан эзэмших, ашиглах ба захиран зарцуулах эрхийг хэлнэ. Эзэмших гэж эзэмшигч эд хөрөнгийг бодитой эзэмдэж түүнд шууд нөлөөлөх боломжтой болсныг хэлнэ. Дээрх заалт нь өмчлөгчийн эрхийг Үндсэн хуулийн хүрээнд чухалчлан хамгаалсны учир нь өмчлөх эрх хувь хүний хамгаалалтын бүс үүсгэдгээрээ төрийн дур зоргоор авирлахын эсрэг хувь хүний орон зайг бий болгож, бусад эрх, эрх чөлөөгөө эдлэх боломжийг бүрдүүлдэг учраас өмчлөх эрхийг ийнхүү тусгайлан баталгаажуулжээ.

Дээрхээс үзвэл, аливаа этгээд нь хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх үндсэн эрхтэй байх бөгөөд тухайн шударгаар олж авсан өөрийн хөрөнгийг банкинд хадгалах, эдийн засгийн эргэлтэд оруулах замаар банкинд данс нээлгэж байршуулах, данс эзэмших эрхээр тайлбарлагдана. Энэ үндсэн эрх нь Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 12.1 дэх хэсэгт заасан “Иргэн, хуулийн этгээд тогтоосон журмын дагуу банк, төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдэд данс нээлгэж, төлбөр тооцооны үүрэг гүйцэтгүүлэх эрхтэй.” гэж заасан агуулгаар баталгаажжээ.

Гэтэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2.13 дахь заалт нь иргэн хүний “... банк, эрх бүхий хуулийн этгээдэд данс нээх, эзэмших эрхэд хязгаарлалт тогтоох, ...” эрхийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад олгосон байна.

Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны үндэс нь иргэний болон захиргааны хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр, эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийтгэх тогтоол, хуульд заасан тохиолдолд бусад байгууллагын гаргасан шүүхийн шийтгэх тогтоол, хуульд заасан тохиолдолд бусад байгууллагын шүүхээр баталгаажуулсан шийдвэрийг биелүүлэх процесс билээ. Харин шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах арга хэмжээ гэдэгт шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохистой хэрэгжүүлэхийн тулд

шийдвэр гүйцэтгэгчийн хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу хэрэгжүүлэх арга хэмжээг ойлгоно. Банк, эрх бүхий хуулийн этгээдэд данс нээх, эзэмших эрхэд хязгаарлалт тогтоохоор байгаа нь дээрх ажиллагаанд шууд багтаж байна.

Данс гэдэг нь банкны бүртгэлийн систем буюу банкинд өөрийн хөдлөх хөрөнгийг /мөнгө/ байршуулж буй үйлчлүүлэгчийн хөрөнгийг бүртгэх бүртгэлийн систем бөгөөд банкинд байршуулж буй үйлчлүүлэгчийн хөдлөх хөрөнгийг өөртөө агуулж байгаа ойлголт юм. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2.13 дахь заалтыг авч үзвэл хэрэв шийдвэр гүйцэтгэгч энэ арга хэмжээг авсан тохиолдолд төлбөр төлөгч аль ч банкинд данс нээх, данс эзэмших эрхгүй болж байна. Данс нээх, эзэмших эрхгүй болно гэдэг нь төлбөр төлөгч өдөр тутмын амьдралын зайлшгүй шаардлагатай төлбөр тооцоог хийж, аж ахуйн болон амины үйл ажиллагаагаа саадгүй явуулах боломжгүй болохоор байна. Тиймээс энэ нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад “хөдлөх ... хөрөнгө эзэмших, өмчлөх ... эрхтэй. ...” үндсэн эрхийг хязгаарлаж буй хязгаарлалт мөн.

Гэтэл уг хязгаарлалт нь мөн л хууль ёсны бус байгаад оршиж байна. Учир нь Нэгдүгээрт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2.13 дахь заалтад банк, эрх бүхий хуулийн этгээд дэх төлбөр төлөгчийн мөнгөн хадгаламж харилцах дансан дахь хөрөнгөөс суутгал хийх, дансны зарлагын гүйлгээг хаах, эзэмшиж байгаа дансны орлого, зарлагын гүйлгээнд хяналт тавих зэрэг өөр төрлийн баталгаажуулах арга хэмжээг тусгасан байна. Мөн түүнчлэн, төлбөр төлөгчид үүрэг бүхий төлбөр төлөхөөс гадна өдөр тутамд олон төрлийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан цахим хэлбэрээр мөнгөн гуйвуулга хийх, хүүхдийн тэтгэлгийн мөнгө, хүүхдийн мөнгөн хадгаламж, тэтгэвэр, тэтгэмжийн орлого зэрэг зайлшгүй хэрэгцээт мөнгөний эх үүсвэртэй холбоотойгоор данс нээх шаардлага амьдралд тулгарч болно. Тийм учир “банк, эрх бүхий хуулийн этгээдэд данс нээх, эзэмших эрхэд хязгаарлалт тогтоох” нь төлбөр төлөгчийн төлбөр авагчид төлбөр барагдуулах үйл явцад ач холбогдолтой нөлөө үзүүлж чадахгүй байх тул Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44 дүгээр зүйлд заасан иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах арга хэмжээний зорилгод нийцэхгүй байна. Хоёрдугаарт, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2.13 дахь заалтад заасан бусад арга хэмжээнүүд нь төлбөр авагч болон шийдвэр гүйцэтгэгч хоёр талд хангалттай механизмыг бүрдүүлсэн байна гэж үзэх үндэслэлтэй. Жишээ нь, шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн эзэмшиж буй эсхүл шинээр нээлгэсэн дансны орлого, зарлагын гүйлгээнд хяналт тавих бүрэн боломжийг хуульчилжээ. Тиймээс банк, эрх бүхий хуулийн этгээдэд данс нээх эзэмших эрхэд хязгаарлалт тогтоох нь зайлшгүй шаардлага биш болох нь үүгээр батлагдана. Гуравдугаарт, мөн Үндсэн хуулийн дагуу хөдлөх хөрөнгө эзэмших үндсэн



эрхийг хуулиар хязгаарлах боломжийг тусгаж өгсөн ч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2.13 дахь заалтад заасан хязгаарлалт нь хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, орлогын болон амьдралын нэн зайлшгүй эх үүсвэрийг хязгаарлахгүй байх болон төр, хүний үндсэн эрх хоёрын зохистой харьцааны Үндсэн хуулийн суурь зарчмыг зөрчөөд зогсохгүй шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зарчимд ч нийцэхгүй байна.

Тиймээс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2.13 дахь заалтын "... банк, эрх бүхий хуулийн этгээдийн данс нээх, эзэмших эрхэд хязгаарлалт тогтоох, ..." гэсэн хэсэг нь Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн "... өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.", Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтын "хөдлөх ... хөрөнгө эзэмших, өмчлөх ... эрхтэй. ..." гэсэн хэсгийг тус тус зөрчсөн байна.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн." гэж тогтоосон байдаг. Энэхүү зарчим нь төрийн аливаа хэлбэрийн үйл ажиллагаанд бодитой баримтлагдан хэрэгжих тулгуур зарчим мөн.

Дээрх зарчмын агуулгыг бэхжүүлсэн холбоо уялдаа бүхий заалт бол Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна." гэж тодотгосон юм. Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх нь хууль тогтоох гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийн бүхий л үйл ажиллагаанд баримтлах ёстой үүрэгжүүлсэн заалт мөн.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.3 дахь хэсэгт "Барьцаалагч-төлбөр авагч" биш этгээд өөрт учирсан хохирлыг төлбөр төлөгчийн үл хөдлөх хөрөнгөөс гаргуулах гэж дуудлага худалдаагаар оруулсан боловч тухайн үл хөдлөх хөрөнгө нь худалдан борлогдоогүй бол тухайн үл хөдлөх хөрөнгийн үнийг 50 хувь бууруулна гэсэн зарчмыг тогтоожээ. Өөрөөр хэлбэл, төлбөр авагч нь барьцаалагч байсан тохиолдолд зах зээлийн ханшаар тооцно, харин барьцаалагч биш төлбөр авагч бол дуудлага худалдаагаар борлогдоогүй үнийг 50 хувиар бууруулж төлбөр авагчид шилжүүлэхээр буюу өөр, өөр үнээр тооцож шилжүүлэхээр зохицуулсан байна.

Ингэж төлбөр авагчдын эрх зүйн байдлыг ялгамжтай үзэж, ялгавартайгаар зохицуулсан нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "... шударга ёс, ... тэгш байдлыг ... хангах, ... нь төрийн үйл ажиллагааны зарчим мөн", Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "... хүн бүр хуулийн ... өмнө эрх тэгш байна." гэсэн заалтыг зөрчиж байна. Учир

нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.5 дах хэсэгт “Барьцаалагч-төлбөр авагчийн барьцаанд байгаа, эсхүл дундын өмчлөлийн худалдан борлогдоогүй төлбөр төлөгчид ногдох хөрөнгийг энэ хуулийн 55.3-т заасны дагуу тогтоосон үнэлгээгээр тооцож төлбөр авагчид шилжүүлнэ.” гэсэн байна. Нэгдүгээрт, барьцаалагч биш төлбөр авагчийн эрхийг нь хязгаарлаж, бусад төлбөр авагчийн эрхээс дордуулж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар төлбөр авагчдад тэгш бус ялгавартай ханджээ. Гэтэл барьцаалагч нь төлбөр авагч бол шинжээчээр үнэлүүлсэн тохиолдолд шинжээчийн үнэлгээгээр 50 хувь бууруулах зохицуулалт байхгүй. Хоёрдугаарт, төлбөр авагч гэж ажил үйлчилгээний үнэ хөлс, нийлүүлсэн бараа, бүтээгдэхүүний үнийг төлбөр тооцооны тодорхой хэлбэрийн бүрдүүлбэрийг хангасан баримтын дагуу нэхэмжилсэн этгээд байна. Гэтэл төлбөр авагчийг “барьцаалагч-төлбөр авагч”, барьцаалагч биш төлбөр авагч гэж тусад нь ангилж хуульчилсан нь хууль зүйн дагуу үүсэх үр дагаврыг ойлгомжгүй болгосон байна. Түүнчлэн, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндсэн дээр өөрийн хохирлыг нөхөн төлүүлэх эрхээ эдлэх процессыг нэг ойлголт дор байгаа адил этгээдүүдэд ялгавартайгаар хуульчилсан нь үндэслэлгүй юм. Гуравдугаарт, хууль тогтоогч тухайн заалтыг ямар үндэслэл зарчмаар, ямар зорилго агуулж тогтоосон нь тодорхойгүй, ач холбогдол, эрх зүйн үр дагаврыг нь бүрэн ухамсарлаагүй харагдаж байна. Дөрөвдүгээрт, хууль тогтоогч дээрх зохицуулалтыг хийхдээ зөвхөн банкны барьцааны асуудлаар төсөөлж хийсэн нь хэт явцууруулжээ. Тэгвэл Иргэний хуульд заасан үүргийн гүйцэтгэлийг хангах барьцааны нийтлэг шинж, зохицуулалтыг огт анхаараагүй тогтоосон байна. Иргэний хуульд заасан худалдах, худалдан авах гэрээ, зээлээр худалдах, худалдан авах гэрээ, эд хөрөнгө хөлслөх гэрээ, орон сууц хөлслөх гэрээ, түрээсийн гэрээ, ажил гүйцэтгэх зэрэг гэрээний барьцаалагчдын хувьд тэдгээрийн эрх зүйн байдлыг дордуулж, ялгаварлал бий болгосон байна. Тавдугаарт, мөн хууль тогтоогч “... Худалдан борлогдоогүй хөрөнгийн үнэ” гэдэгт чухам ямар үнэ хамаарахыг тодорхой хуульчлаагүй нь маргаан дагуулах эх сурвалж болжээ. Үүнд тухайн худалдан борлогдоогүй хөрөнгийн зах зээлийн үнэ хамаарах уу, эсхүл хөрөнгийн үнэлгээний шинжээчийн тогтоосон үнэ хамаарах уу гэсэн маргааны нэг нөхцөл болж байна.

Тиймээс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 73.5-д зааснаас бусад тохиолдолд дуудлага худалдаагаар худалдан борлогдоогүй үл хөдлөх хөрөнгийг төлбөр авагчид шилжүүлэхдээ түүний үнийг 50 хувиар бууруулж тооцон олгоно. Худалдан борлогдоогүй хөрөнгийн үнэ гүйцэтгэх баримт бичигт заасан төлбөрийн шаардлагаас илүү дүнтэй бол төлбөр авагч үнийн дүнгийн зөрүүг төлснөөр худалдан борлогдоогүй хөрөнгийг хүлээн авах эрх нээгдэнэ.” гэж бусдын амьжиргааны эх үүсвэр болсон үл хөдлөх хөрөнгийг залгих хууль бус ажиллагааг хөхиүлэн дэмжсэн, нөгөө талаас банк зэрэг санхүүгийн ашгаар амьдардаг байгууллагын зорилгод өөр





хэлбэрээр буюу бага зардлаар хүний үл хөдлөх хөрөнгийг залгих далд утгаар ашиг олох боломж бүрдүүлж байгаа нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "... шударга ёс, тэгш байдлыг ... хангах, ... нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.", Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хуулийн ... өмнө эрх тэгш байна." гэсэн хэсгийг зөрчсөн байна" гэсэн байна.

***Хоёр. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал Үндсэн хуулийн цэцэд хандсан ирүүлсэн тайлбартаа:***

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2.13 дахь заалтад "... банк, эрх бүхий хуулийн этгээдэд данс нээх, эзэмших эрхэд хязгаарлалт тогтоох ..." гэж заасан нь Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "... өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.", Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад "хөдлөх ... хөрөнгө эзэмших, өмчлөх ... эрхтэй. ..." гэж заасныг зөрчөөгүй гэж үзэж дараах үндэслэлийг гаргаж байна:

Хууль тогтоогч шинэчлэн найруулсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх, түргэн шуурхай байдлыг хангах, төлбөр авагч, төлбөр төлөгч иргэний хэн алиных нь эрх, ашиг сонирхол, тэдгээрийн Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрч, тогтоосон эрх, эрх чөлөөг хамгаалах зорилго бүхий олон шинэлэг зохицуулалтуудыг тусгасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Төр нь ... өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална." гэж заасан нь өмчлөгчийн эрхэд огт халдаж болохгүй гэсэн агуулгыг агуулаагүй, уг зүйлд өмчлөгчийн эрхийг хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болох агуулга бүхий заалт бас бий. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44 дүгээр зүйлд иргэний хэргийн талаар Монгол Улсын нэрийн өмнөөс гарсан хуулийн хүчин төгөлдөр, заавал биелэгдэх шинжтэй шүүхийн шийдвэрт заасан төлбөрийг төлбөр төлөгч биелүүлж, төлбөр авагчийн эрх, ашиг сонирхлыг хангахад чиглэсэн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг баталгаажуулах арга хэмжээг хуульчилсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2.13 дахь заалтад "... банк, эрх бүхий хуулийн этгээдэд данс нээх, эзэмших эрхэд хязгаарлалт тогтоох, ..." гэсэн зохицуулалтыг тусгасан нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан шүүхийн шийдвэр заавал биелэгдэх, иргэнд учирсан гэм хорыг арилгах заалтын биелэлтийг хангуулах, мөн өмчлөгчийн эрхийг хуульд заасан тохиолдолд хязгаарлаж болох заалтад нийцүүлсэн болно. Өөрөөр хэлбэл, төлбөр төлөгчөөс шүүхийн шийдвэрт

заасан төлбөрийг төлөхөөр шийдвэр гүйцэтгэх байгууллагад анх мэдүүлсэн банк, эрх бүхий хуулийн этгээд дэх өөрийн нэр дээрх дансаа ашиглаж орлого хийхгүй царцааж, хөрөнгө орлогоо нууж, шинээр данс нээн түүгээрээ орлого, зарлагын гүйлгээгээ хийж, төлбөр төлөх үүргээсээ зайлсхийж, шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулсан тохиолдолд төлбөр төлөгчийн шинээр данс нээх, эзэмших эрхэд хязгаарлалт тогтоох арга хэмжээг шийдвэр гүйцэтгэгч хэрэгжүүлж болохоор хуульчилсан.

Энэ нь нэг талаас шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэмэгц шийдвэр гүйцэтгэгчээс бүх төлбөр төлөгчид, даруй авах арга хэмжээ бус харин дээр дурдсан шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулсан, шүүхийн шийдвэр биелэгдэхгүй, төлбөр авагчийн эрх хангагдахгүй байх нөхцөл байдлыг бий болгосон, хууль зөрчсөн төлбөр төлөгчид л авах арга хэмжээ гэж ойлгож байна.

Төлбөр төлөгчөөс дээр дурдсан байдлыг гаргахгүй тохиолдолд өөрийн нэр дээр данс нээх, эзэмших эрхэд хязгаарлалт тогтоох үндэслэл үүсэхгүй. Төлбөр төлөгч хөрөнгөд орсон өөрчлөлтөө хуульд заасны дагуу шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэх үүрэг нь мөн хуулийн 46 дугаар зүйлээр нээлттэй байгаа.

Нөгөө талаас шийдвэр гүйцэтгэгч үндэслэлгүйгээр дээрх арга хэмжээг авсан гэж үзэж зөвшөөрөхгүй байгаа тохиолдолд төлбөр төлөгчид ахлах болон ерөнхий шийдвэр гүйцэтгэгчид хандаж гомдол гаргах эрхийг мөн хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4, 44.5 дахь хэсгээр олгосон.

Мэдээлэл гаргагчийн мэдээлэлд дурдсанчлан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2.13 дахь заалтад төлбөр төлөгчийн банк, эрх бүхий хуулийн этгээдэд данс нээх, эзэмших эрхэд хязгаарлалт тогтоож болохоор хуульчилсан нь төлбөр төлөгч данс ашиглан хэрэгжүүлэх амьдралын наад захын хэрэгцээ, шаардлагаа хангах боломжийг үгүйсгэсэн агуулга огт байхгүй.

Төлбөр төлөгчийн тодорхой эрхэд хязгаарлалт тогтоосон ч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 87, 88, 89 дүгээр зүйлд заасанчлан төлбөрт суутгаж болохгүй, хураан авч, битүүмжилж болохгүй зайлшгүй шаардлагатай хөрөнгөө захиран зарцуулах, дансанд байршуулах эрх нь нээлттэй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.13 дахь заалтын агуулга нь төлбөр төлөгчийн данс нээх, эзэмших эрхэд нь хязгаарлалт тогтоох, дансны орлого, зарлагын гүйлгээнд нь хяналт тавих утгатай бөгөөд гагцхүү төлбөр төлөгч өөрийн хөрөнгийг нуун далдлах зорилгоор олон төрлийн данс эзэмших, түүгээр дамжуулан гүйлгээ хийх явдлыг л хязгаарлах зорилготой.



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 73.5-д зааснаас бусад тохиолдолд дуудлага худалдаагаар худалдан борлогдоогүй үл хөдлөх хөрөнгийг төлбөр авагчид шилжүүлэхдээ түүний үнийг 50 хувиар бууруулж тооцон олгоно. ...” гэж заасан нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... шударга ёс, ... тэгш байдлыг ... хангах, ... нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль ...-ийн өмнө эрх тэгш байна.” гэж заасныг зөрчөөгүй гэж үзэж дараах үндэслэлийг гаргаж байна:

Хууль тогтоогч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 73 дугаар зүйлд төлбөр төлөгчийн худалдан борлогдоогүй хөрөнгийг төлбөр авагчид санал болгохтой холбогдсон харилцааг зохицуулсан бөгөөд ийнхүү зохицуулахдаа 73.3 дахь хэсгээр төлбөр авагчийн барьцаанд байгаа болон дундын өмчлөлийн хөрөнгөөс төлбөр төлөгчид ногдох хөрөнгөөс бусад хөрөнгийг түүний үнэлэгдсэн үнээс 50 хувиар бууруулан төлбөр авагчид санал болгохоор, 73.5 дахь хэсгээр төлбөр авагчийн барьцаанд байгаа болон дундын өмчлөлийн хөрөнгийн төлбөр төлөгчид ногдох хэсгийг шинжээчээс тогтоосон үнээр төлбөр авагчид санал болгохоор тус тус хуульчилсан.

Иргэний хууль тогтоомжид заасанчлан барьцааны үүрэг талуудын чөлөөт хүсэл, зоригийн үндсэн дээр буюу талууд өөрсдийн эрсдэлийг тооцож, тохиролцсон үед үүсдэг.

Өөрөөр хэлбэл, барьцаалагч, барьцаалуулагч нь аливаа хөрөнгийг харилцан тохиролцсоны дагуу барьцааны зүйл байхаар сонгодог буюу барьцаалагч-төлбөр авагч үүргийн гүйцэтгэлийг хангуулах барьцааны зүйлийг өөрөө сонгож хэлцэл байгуулдаг тул барьцаалагч-төлбөр авагч сонголтынхоо эрсдэлийг өөрөө үүрэх буюу түүнд тусгайлсан зохицуулалт үйлчлэх нь гарцаагүй юм. Тодруулбал, иргэн, хуулийн этгээд зээлийн гэрээ байгуулахдаа зээлдэгч /үүрэг гүйцэтгэгч/ үүргээ биелүүлээгүй тохиолдолд тухайлсан барьцааны зүйлийг үүргийн гүйцэтгэлд тооцож тэргүүн ээлжид төлбөрийн шаардлагаа хангуулах эрхээ эдлэх хүсэлтээ илэрхийлсэн байдаг тул барьцааны зүйлээр түүний үүргийн гүйцэтгэлийг хангуулан тухайн хөрөнгийг төлбөр авагчид шилжүүлэх зохицуулалтыг хуульчилсан.

Ийнхүү зохицуулсан нь барьцааны зүйлээр төлбөрийн шаардлагыг бүрэн хангуулах, үүргийн гүйцэтгэлийг барьцаалагдаагүй бусад хөрөнгөөс гаргуулахгүй байж төлбөр төлөгчийн өмчлөх эрхийг хамгаалахад чиглэсэн зохицуулалт болж чадсан.

Харин энгийн төлбөр авагч буюу барьцаалагч бус төлбөр авагчийн хувьд дээр дурдсанчлан үүргийн гүйцэтгэлийг хангуулах аливаа хэлбэр, барьцааг сонгоогүй, тухайн хөрөнгийг үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар буюу төлбөртөө суутган авахаар хэлэлцэн тохиролцож гэрээ хийгээгүй байдаг. Тодруулбал, иргэн, хуулийн этгээд зээлийн гэрээ байгуулахдаа үүргийн гүйцэтгэлд аливаа эд хөрөнгө авахгүйгээр мөнгөн хэлбэрээр нь эргүүлж авна гэж тооцож хэлцэл хийсэн байдаг. Энэ тохиолдолд шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангах үүднээс төлбөр төлөгчийн хоёр шатны дуудлага худалдаагаар ороод худалдан борлогдоогүй хөрөнгийн үнийг тодорхой хувиар бууруулан төлбөр авагчид санал болгохоор зохицуулсан.

Иймд Монгол Улсын Үндсэн хуульд заасан тэгш байдал, эрх тэгш байх зарчимд нийцүүлэн хууль тогтоогч өөр өөр нөхцөлөөр үүссэн харилцаанд тохирсон онцлогтой зохицуулалтыг хуульчилсан нь Үндсэн хуулийн зөрчлийг агуулахгүй гэж үзэж байна” гэсэн байна.

### ҮНДЭСЛЭЛ:

1. Иргэн Т.Мөнх-Эрдэнэ Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны явцад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 73.5-д зааснаас бусад тохиолдолд дуудлага худалдаагаар худалдан борлогдоогүй үл хөдлөх хөрөнгийг төлбөр авагчид шилжүүлэхдээ түүний үнийг 50 хувиар бууруулж тооцон олгоно. ...” гэж заасан нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... шударга ёс, ... тэгш байдлыг ... хангах, ... нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль ...-ийн өмнө эрх тэгш байна.” гэж заасныг зөрчсөн гэсэн мэдээллийн шаардлагаасаа татгалзсан болно.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Төр нь ... өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.”, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно.” хэмээн хуульчилжээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 44 дүгээр зүйлийн 44.2.13 дахь заалтад “... банк, эрх бүхий хуулийн этгээдэд данс нээх, эзэмших эрхэд хязгаарлалт тогтоох, ...” гэж зааж, хуулийн хүрээнд өмчлөх эрхийн хэрэгжилтэд хязгаарлалт тогтоосон нь хууль тогтоогчийн бүрэн эрхэд хамаарч байх ба Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг агуулагүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон



**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС  
ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:**

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2.13 дахь заалтад "... банк, эрх бүхий хуулийн этгээдэд данс нээх, эзэмших эрхэд хязгаарлалт тогтоох, ..." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн "... өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.", мөн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтын "хөдлөх ... хөрөнгө эзэмших, өмчлөх ... эрхтэй. ..." гэснийг зөрчөөгүй байна.

2. Мэдээлэл гаргагч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.3 дахь хэсэгт холбогдох мэдээллийн шаардлагаасаа татгалзсан болохыг дурдсугай.

3. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**ДАРГАЛАГЧ**

**Н.ЖАНЦАН**

**ГИШҮҮД**

**Ш.ЦОГТОО  
Н.ЧИНБАТ  
Д.СОЛОНГО  
Д.ГАНЗОРИГ**

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 1.25

**Индекс: 200003**